



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 1129

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/793 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тулгар төрийн 2233 жил, Их монгол улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадам, “Үндэсний хувцасны өдөр”-ийг тохиолдуулан “Дээлтэй диско” арга хэмжээг зохион байгуулсугай.

2. “Дээлтэй диско” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулан, нэгдсэн удирдлагаар ханган, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 07 сарын 04 өдрийн
..... А/27 дугаар тушаалын хавсралт



“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ-2024” НААДМЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Талбайн тохижилтын зардал				
1	“Дээлтэй Диско”	Багц	15,000,000	15,000,000
Нийт дүн				15,000,000